



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/514

Арвайхээр


Тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "г", Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5.1, 13.5.4, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргад хандан гэр хүсч өргөдөл ирүүлсэн Арвайхээр сумын 11 дүгээр багийн иргэн С.Болдын гэр нь цахилгааны аюулгүй байдлын улмаас шатсан тул иж бүрэн 5 ханатай гэр олгоход 3,600,000 (гурван сая зургаан зуун мянга) төгрөг зарцуулсугай.

2.Дээрх 3,600,000 (гурван сая зургаан зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101143